



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#5

2022 он





VIII сар

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

Боловсролын ирээдүйн чиг хандлага-баримт бичгийн шинжилгээний тухай

БСҮХ-гийн захирлын БШУЯ-ны сайдтай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн гэрээний дагуу БХИССС-ын ЭША-ууд Боловсролын ирээдүйн чиг хандлагад баримт бичгийн шинжилгээ хийж эхлээд байна. Шинжилгээнд дараах баримт бичгүүдийг сонгосон болно.



Ирээдүйн боловсролыг цогцлоход баримтлах үзэл санаа, хандлага болон бодлого шийдвэрийн хувьд анхаарах асуудлыг уг баримт бичгүүдийн хүрээнд хэрхэн авч үзсэнийг илрүүлэх нь баримт бичгийн шинжилгээний зорилт бөгөөд дэлхий дахинд ирээдүйн боловсролын талаар хэрхэн төсөөлж, ямар бодлого чиглэл дэвшүүлж байгаа нь боловсрол судлаачдын хувьд ач холбогдолтой байх болно.


СУРГАЛТ



БШУЯ, БЕГ, БСҮХ хамтран зохион байгуулсан “Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил-зөвлөх багшийн манлайлал” сэдэвт Үндэсний хэмжээний сургалт, зөвлөгөөнд бага ангийн болон математик, мэдээлэл зүйн зөвлөх багш нарт “Монгол хүүхдийн цогц хөгжлийн судалгаа”-ны үр дүнгээс танилцууллаа.

Иргэдийн санхүүгийн боловсрол олгох хэрэгцээг тодруулсан судалгааны үр дүн


Зураг 1. Үндсэн чиглэлийн сургалтанд хамрагдсан иргэд



Иргэдийн санхүүгийн суурь мэдлэг, боловсролыг дээшлүүлснээр өрхийн төсвөө төсөвлөх, төлөвлөх, хариуцлагатайгаар зээл авах, хөрөнгийн зах зээлд оролцох, санхүүгийн залилангаас сэргийлэх гэх мэтээр хувь хүн бүтээмжээ дээшлүүлэх боломжтой юм. Судалгааны үр дүнгээс харахад цаашид санхүүгийн болон бизнесийн боловсролыг үе шаттайгаар зорилтот бүлгүүдэд олгох шаардлага, хэрэгцээ байна.

- Гадаад болон дотоодын байгууллагаас санхүүгийн боловсролыг иргэдэд олгох сургалтыг дэмжих, хамтарч ажиллах
- Их дээд сургуулийн багшийн хөгжлийн хүртээмжийг нэмэгдүүлж, багшийн хөгжлийг энэ чиглэлээр дэмжих, урамшуулах тогтвортой механизмыг бүрдүүлэх зэрэг болно.

Зураг 2. Насан туршийн боловсролын үйлчилгээ хүртэгсэд



Эх сурвалж: ЮНЕСКО, 2016. НТБ-ын хүрээлэн, Насанд хүрэгчдийн боловсролын дэлхийн тайлан

Дээд боловсролын бакалаврын хөтөлбөрийн хүртээмжид хийсэн шинжилгээ

Улс орнуудын боловсролын хөгжлийн төлөв байдалтай уялдаатай хүртээмж, чанарын асуудлыг чухалчилдаг. Бид ур чадварыг хүртээмжтэй олгож, олон улсад өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургууль, коллежийн бакалаврын хөтөлбөр, бакалаврын зэргийн сургалтад элсэн суралцахад тавигдах шаардлага, цуглуулбал зохих багц цаг, үргэлжлэх хугацаа зэргийг харьцуулан судалж, Монгол улсын дээд боловсролын хөтөлбөрийн хүртээмж ямар байгааг, мөн суралцагчдын ур чадварыг хөгжүүлж чадаж байгаа эсэхийг судалгааны үндсэн дээр гаргаж тавихыг зорилоо.

Судалгааны үр дүнгээс дараах саналуудыг гарсан болно. Үүнд:

- Бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурийн бүтэц, агуулгыг нийгмийн болон суралцагчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох
- Ерөнхий суурийн хэсэгт нийгэм, соёлын болон шинжлэх ухаан технологийн сүүлийн үеийн ололт амжилт, хөгжлийн чиг хандлагыг тусгасан сонгон судлах хичээлийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Нийгмийн түншлэлийн хүрээнд хамтарч ажиллалаа



БШУЯ, БЕГ, БСҮХ хамтран зохион байгуулсан “Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил-зөвлөх багшийн манлайлал” сэдэвт Үндэсний хэмжээний зөвлөх багш нарын сургалт зөвлөгөөнд монгол хүүхдийн цогц хөгжлийг сургалт хөгжлийн үйл ажиллагаагаар дэмжих арга зүйг судалгааны үр дүнд тулгуурлан танилцууллаа.

Танилцуулгыг СӨБ, сургуулийн бага нас, өсвөр насны хүүхдийн хөгжлийн хүрээнд авч үзэж, бусад эрдэм шинжилгээний ажилтнуудын хамт хийсэн нь “Монгол хүүхдийн цогц хөгжийн судалгаа”-ны үр дүнг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх арга зүйн ажил боллоо.

Дэлхийн зөн ОУБ, Азийн сан хамтран АНУ болон Монгол Улсын Засгийн газрын 2020 онд байгуулсан Хүүхэд Хамгааллын Түншлэлийн Компакт гэрээний дагуу “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд Үндэсний хэмжээнд ЕБС-д хэрэгжих “Ухаалаг хөтөч”, “Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой” нэртэй 2 хөтөлбөрийн агуулга арга зүйд мэргэжлийн үнэлгээ дүгнэлтийг хийсэн.

Харвард коллежийн ерөнхий суурийн 4 чиглэлийн зорилго



Урлагийн төрөл, соёл уламжлалыг судалж, урлагийн бүтээлийг ойлгох, соёлын үйл ажиллагаанд оролцох мэдлэг, чадвартай болох



Оюутнуудад юу нь зөв болох, юу нь буруу болохыг ойлгуулах, иргэншлийн мөн чанар, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөхөд суралцах



Ижилсэл, ондоошил, нийгмийн өөрчлөлт, хүн төрөлхтөний хөгжлийн түүх, уламжлалыг таньж мэдэх, ойлгоход туслах



Шинжлэх ухаан, инноваци, нийгмийн нөхцөл байдлыг судалж, судалгаа шинжилгээний аргуудыг ашиглан хөгжлийн өнөөдрийн болон ирээдүйн алдаа оноог үнэлж дүгнэх чадвар эзэмшихэд туслах

Дээрх 4 чиглэлийн зорилгын хүрээнд суралцагчдын нийгмийн болон хувь хүний хэрэгцээт ур чадварыг хөгжүүлж байна.



Монгол улсын боловсролын салбарын цахим шилжилтийн өнөөгийн байдал



Монгол Улс “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”, “Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого”, “Цахим үндэстэн дунд хугацааны зорилтот хөтөлбөр 2022-2027”, “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө” зэрэг

боловсролын салбарт цахим технологи нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгов.

2019 оноос дэлхий нийтийг хамарсан “Covid-19” нь улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний дотор боловсролыг хувирган өөрчлөх хэрэгцээг бий болгож, цар тахлын үед хариу арга хэмжээ авах, ирээдүйд тохиолдож болзошгүй эрсдэлт, гамшгийн нөхцөлд бэлэн байхын тулд цахим, холимог сургалтыг чанартай зохион байгуулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд цахим технологийг ашиглаж байна.

Өгөгдөл боловсруулалт, цахим судалгаа хөгжүүлэлтийн болон Боловсролын хөгжлийн ирээдүй судлал судалгааны секторууд хамтарч Монгол Улсын боловсролын цахим шилжилтийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг удирдлага, зохион байгуулалт, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүй, хүний нөөцийн цахим ур чадвар, дэд бүтэц, цахим хэрэглэгдэхүүн, боловсролын санхүүжилт зэрэг чиглэлээр тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг дэвшүүлэв.

Материаллаг бааз, техник технологи



Боловсролын хүрээлэн нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Засгийн газрын агентлаг байгуулах тухай” 403 дугаар тогтоолын дагуу “Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн” болж өргөжсэнтэй холбоотой хүрээлэнгийн веб сайт шинэчлэгдсэн.

Өгөгдөл боловсруулалт, цахим судалгаа хөгжүүлэлтийн секторын эрдэм шинжилгээний ажилтнууд “mnier.mn” веб сайт шинэчлэх ажилд хөгжүүлэгч нартай хамтран ажиллаж байна.

“Tableau” программын хоёр эрхийг Боловсролын мэдээллийн технологийн төвөөс авч, хүүхдийн цогц хөгжлийн өгөгдлийг оруулан ажиллаж байна.



Англи хэлний зуны эрчимжүүлсэн сургалт амжилттай зохион байгуулагдлаа



БСҮХ-гийн Гадаад хэлний төвөөс ЕБС-ийн англи хэлний багш нарын мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Боловсролын Ерөнхий Газар, 18 аймгийн БШУГ, 3 дүүргийн боловсролын хэлтсүүдтэй хамтран “Англи хэлний зуны эрчимжүүлсэн сургалт” -ыг 7 дугаар сарын 25-аас 8 дугаар сарын 26-нд

5 долоо хоногийн хугацаатай танхим болон цахим хэлбэрээр үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Сургалтыг үндэсний их, дээд сургуулийн багш нар болон TESOL (англи хэлийг гадаад хэл болгох заах арга зүй эзэмшсэн) зэрэгтэй, АНУ-ын Засгийн газрын “TEA” тэтгэлэгт хөтөлбөр төгссөн 27 сургагч багш удирдан явууллаа.

“Англи хэлний зуны эрчимжүүлсэн сургалт”-ын ЦАХИМ ХЭЛБЭР


Learning styles

- 11. recite (v)=to say or repeat out loud
- 12. kinesthetic (adj)=related to body motion
- 13. conventional (adj) =normal; traditional
- 14. fidget (v)=to move constantly in a nervous manner
- 15. manipulate (v)=to move things around with the hands
- 16. incorporate (v)=to add in;bring together
- 17. encouragement (n)=praise;support to keep going
- 18. solitary (adj)=done alone; independent
- 19. expose (v)=to give an opportunity to experience or learn new things
- 20. dominant (adj)=more important, stronger

Participants in the meeting: Tsermaa, Tungalagtamir, Dashriimaa, Otgontuya, Khongorzul, gankhuyag, Tungalagtamir, Sarangerel, You, Khongorzul, Sarantsetseg, altantsetseg, Enkhbayar, Deegli, sanchirmaa, Uyanga, 6 others.

“Англи хэлний зуны эрчимжүүлсэн сургалт”-д Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн төвийн болон сумдын ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний 517 багш хамрагдсан байна.

PISA-МОНГОЛД



“PISA-МОНГОЛД: PISA гэж юу вэ? Хэмжиж удирдах нь” нэртэй тус гарын авлагыг боловсролын салбарын бодлого боловсруулагч, удирдах ажилтан, мэргэжилтнүүд болон багш, сурган хүмүүжүүлэгчдэд зориулан PISA-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, түүний ач холбогдлыг таниулах зорилгоор СХҮСБСС-ын эрхлэгч Х.Отгонбаатар БҮТ-тэй хамтран боловсруулан гаргасан байна.

Гарын авлагад PISA-ийн түүхэн хөгжил, онцлог, ач холбогдол, боловсролын бодлогод түүний үзүүлэх нөлөө, үүрэг, дэлхийн улс орнуудын PISA-ийн амжилтыг боловсролын загвартай харьцуулсан судалгааны үр дүн, PISA-ийн жишиг даалгаврын танилцуулга, тайлбар багтсан.

“Эрүүл мэндийн боловсрол” гарын авлагын хэрэглээ, ач холбогдол

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох “Эрүүл мэндийн боловсрол” багшийн гарын авлагыг БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр боловсруулсан. Тус гарын авлагын хэрэглээ, ач холбогдлыг тандах судалгааг асуулгын аргаар авч, үр дүнг гаргажээ. Судалгааны зарим үр дүнгээс тодруулбал, оролцогчдын 55 орчим хувь нь бага насны хүүхдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжихэд багш нарт тулгарч буй асуудалд арга зүйн зөвлөгөө, гарын авлага, хэрэглэгдэхүүн мэргэжлийн хүний зөвлөгөө, эцэг эхийн хамтын ажиллагаа дутагдалтай, хүүхдийн тоо олон, ажиллах цаг их гэж тодорхойлжээ.

Эдгээр асуудлыг шийдэхдээ оролцогчдын 45 орчим хувь нь байгууллагын хүрээнд, багаараа ажиллаж шийдвэрлэдэг гэсэн бол үлдсэн хувь нь цахим орчин, мэргэжлийн байгууллагуудын гарын авлага, зөвлөмж, хөтөлбөрийг уншиж, судалдаг гэжээ. Судалгаанд оролцогчид бага насны хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгоход багшид тулгарч буй асуудлыг шийдэхэд тус гарын авлага чухал ач холбогдолтой гэж үнэлэв.

